

МЭРГЭЖЛИЙН /БОГИНО ХУГАЦААНЫ/ СУРГАЛТ ЯВУУЛАХААР "СУРГАЛТЫН ТӨВ" ШИНЭЭР БАЙГУУЛАХ БОЛОН ХУГАЦАА СУНГУУЛАХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АНХААРАЛД:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд нарын А/216, А/104 тоот тушаалаар хамтран баталсан "Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам"-ын дагуу материалаа бүрдүүлэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт албан бичгээ хаяглан /1 давхарт 101тоот/ бичиг хэрэгт өгнө үү.

Дээрх журмыг **Legalinfo.mn** сайтруу орж "Сайдын тушаал" цонхноос актын дугаараар хайн татан авна уу.

Мөн **hudulmur-halamj.gov.mn** сайтруу орж "Хууль эрх зүй" цонхруу орж сайдын тушаал, шийдвэрээс татан авах боломжтой.

МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

1. Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлэх тухай албан бичиг:
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар:
3. Ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн боловсруулсан хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа
4. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв болон Улаанбаатар бүсийн арга зүйн төвийн гаргасан сургалтын хөтөлбөрийн дүгнэлт: *Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн байршил: Монгол Солонгос политехник коллежийн 4 давхарт эсвэл Улаанбаатар бүсийн арга зүйн төвийн байршил: Ганди нэрэмжит Үйлдвэрлэл-Урлалын политехник коллежийн 1 давхарт/*
5. Сургалтын орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, нотлох баримтын хамт: *Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрт заагдсан, мэргэшлийн түвшний шаардлагад нийцсэн сургалтын орчин, техник хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, фото зураг /*
6. Дадлагын сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн байх: */Өөрийн байранд дадлага хийлгэх боломжгүй тохиолдолд аж ахуйн нэгж байгууллага, үйлдвэрийн газартай байгуулсан гэрээний хуулбар/*
7. Багшийн мэдээлэлийг хүснэгтээр гаргасан байх: */Анкет, багш эрхийн үнэмлэх болон боловсролын бичиг баримтын хуулбар /*
8. Харьяа дүүргийн онцгой байдлын хэлтэс болон мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангасан тухай дүгнэлт:
9. Суралцагчидтай байгуулах гэрээний загварыг баталгаажуулсан ТУЗ болон захирлын тушаалын хуулбар:
10. Сургалтын төлбөр тогтоосон шийдвэрээ албажуулсан тухай ТУЗ болон захирлын тушаалын хуулбар
11. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт:
12. Нийгмийн даатгалын хэлтэс, татвар, харилцагч банкны тодорхойлолт:

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗАР

ХОЛБОГДОХ УТАС: 70138004